

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 4 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны хоёрдугаар сарын 14-ний 11 цаг 08 минутад эхэлж, 11 цаг 36 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 28 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Х.Отгонжаргалыг Хөгжлийн бодлогын хэлтсийн даргад нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2016 оны 15 дугаар тогтоолыг цуцлах тухай	“Дүгнэлт гаргах тухай” Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2016 оны 05 сарын 03-ны өдрийн 15 дугаар тогтоолд УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-а,б заалтуудыг зөрчиж, төрийн жинхэнэ албанд ажил эрхлээгүй, удирдах ажилтны сонгон шалгаруулалтад ороогүй Х.Отгонжаргалд дүгнэлт гаргасан, уг тогтоолыг түүний хүргэн ах Л.Ганбат нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасныг зөрчин шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож баталгаажуулсан нь хууль бус захиргааны акт болсон тул хүчингүй болгов.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА